

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2019 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө аймгийн Засаг даргын баталсан 2019 оны 09 сарын 10-ны өдрийн 1/19 дугаар удирдамжийн дагуу Булган аймгийн Сайхан сумын соёлын төвийн 2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд чиглэгдлээ.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.Баттулга, Аудитор П.Пүрэвжав нар 2019 оны 09 сарын 11-ны өдрөөс ажлын 6 өдөр шалгалтыг хийв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Соёлын төвийн 2018 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, шатахууны олголт түүний зарцуулалтыг автомашины замын хуудастай тулгаж, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулан нягтлан бодогч Д.Цэнд-Аюушийг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Булган аймгийн Сайхан сумын соёлын төв нь 2018 онд урлага, уран сайханы арга хэмжээг сумынхаа хэмжээнд хөгжүүлж ажилтан албан хаагчдын чөлөөт цагыг зөв боловсон өнгөрүүлж соёлыг түгээн дэлгэрүүлэхэд шиглэгдсэн байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2018 оны санхүүгийн тайланд аймгийн Аудитын газраас итгэл үзүүлсэн. Өөр газраас шалгалт хийгдээгүй байна

**ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД
ХАМРАГДСАН АСУУДЛУУД**

6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар: 2018 онд улсын төсвөөс 56920.4 мянган төгрөг, нэмэлт санхүүчилтээс 1100.0 мянган төгрөг, өөрийн орлого 1783.8 мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэн ажилсан байна. Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал 34342.5 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 4113.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 17310.5 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 277.3 мянган төгрөг, норматив зардалд 45.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 20.0 мянган төгрөг, томилолтын зардалд 68.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 2184.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

6.2. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт: 2018 он

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж орон сууц	225314400	21669150.51	113713060.12	133270490.39
2	Машин тоног төхөөрөмж	24190603.70	1250000		25440603.70
3	Тавилга эд хогшил	11636624.80			11636624.80
4	Биет бус хөрөнгө		5124000		5124000
5	Програм хангамж	83000			83000
6	Номын фонд	16929409	1296100		18225509
	Дүн	278154037.5	29339250.51	113713060.12	193780227.89

2018 оны эхэнд 278154.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр төсвийн хөрөнгөөр 1411.4 мянган төгрөгийн хөрөнгө авсан хандив тусламжаар 1134.7 мянган төгрөг энэ нь малчин Отгонбаатар нь 1000.0 төгрөгийн утааны аппарат 1 ширхэг тайзны гэрэлтүүлэг 3 ширхэг, Аймгийн төв номын сангаас 134.7 мянган төгрөгийн бэлэглэлийн ном, барилга байгууламж дахин үнэлгээнд орж 5248.6 мянган төгрөгөөр нэмэгдэж Оны эцэст 193780.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгүүлсэн байна.

6.3. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:2018 он

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл

1	Бичиг хэрэг		190500	190500	
2	Аж ахуйн материал	5787285	909000	596800	6099485
3	Түлш тослох материал		46800	46800	
	НИЙТ ДҮН	5787285	1146300	834100	6099485

2018 оны эхэнд 5787.2 мянган төгрөгний бараа материал дээр төсвийн хөрөнгөөр 1146.3 мянган төгрөгний бараа материал худалдан авсан үүнээс бичиг хэрэг 190.5 мянган төгрөг, аж ахуйн материал 909.0 мянган төгрөг, шатах тослах материал 47.8 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна. Тайлант жилийн хугацаанд нийт 237.3 мянган төгрөгийн зардал гарч цаашид ашиглах боломжгүй болсон 596.8 мянган төгрөгийн аж ахуйн материалыг данснаас хасч аклаж устагсан оны эцэст 6099.4 мянган төгрөгний бараа материал бүртгэгдсэн байна.

6.4. Өглөг, авлагын талаар: 2018 онд өглөгө, авлага үүсээгүй байна.

6.5 Шилэн дансны талаар: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд 2018 төсөв гүйцэтгэлийн 49 мэдээлэл оруулхаас 1 мэдээлэл хоцроож, 48 мэдээлэлийг хугацаанд нь оруулсан. Хөрөнгө оруулалт, тендер худалтан авалтын 39 мэдээлэл оруулхаас 1 мэдээлэл хоцроож 38 мэдээлэлийг хугацаанд нь оруулсан бусад 61 мэдээлэл оруулхаас 1 мэдээлэл хоцроож 60 мэдээлэл хугацаанд нь оруулсан байна.

ДОЛОО. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Шалгалтаар 2018 оны 12 сарын 17-ний өдрийн 00135 дугаартай төлбөрийн хүсэлтээр 43.6 мянган төгрөгийг төлбөр хураамжийн зардал данснаас. 12 сарын 17-ний өдрийн 00136 дугаартай төлбөрийн хүсэлтээр 32.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний зардал данснаас гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16.5 /Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: ... 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/-д заасныг зөрчсөн байна.

2. Бараа материалын орлогын баримтыг тухай бүрд үйлдээгүй, агуулахын бүртгэл хөтөлдөггүй нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7-дахь заалтуудыг тус тус зөрчсөн

НАЙМ. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Шалгалтын хугацаанд соёлын төвийн касс, харилцахын баримт бараа матриалын тайлан, аж ахуйн матриалын тайлан, шатхууны тайлан түүний бүрдэлт зэргийг шалгалаа. Цаашид агуулахын бүртгэл нягтлан бодох бүртгэлийн баримтуудыг тухай бүрт нь хөтлөж бүртгэл хөтлөж байх орлогын баримт үйлдэж байх талаар зөвлөгөө өглөө.

ЕС. ДҮГНЭЛТ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.7 дахь /шинэчилсэн/ заалтууд, няравын тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдэлт сайн.

Ололт дэвшилттэй тал нь эд хөрөнгийн тоололгын бүртгэл, хөтлөлт, материалын эмх цэгц сайн байна.

АРВАН . ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Тушаал шийдвэрийн үндэслэлийг хууль эрх зүйн дагуу үг үсгийн алдаагүй гаргах.

Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7-дахь заалтууд, Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр Санхүүгийн хяналт аудитын албанд ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж ажиллах

БИЧСЭН: АУДИТОР

П.ПҮРЭВЖАВ